**ДХХА-НД ШААРДЛАГАТАЙ БУЙ ИНЖЕНЕРҮҮД БОЛОН ТЭДГЭЭРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД**

## 1. Цахилгааны инженер

*Гүйцэтгэх үндсэн үүрэг:*

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Алтанширээ сумаас Дорнод аймгийн Матад сум хүртэл үргэлжлэх “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн захиалагчийн багт инженерчлэлийн зураг төсөл, барилга угсралтын ажилд хяналт тавих, норм дүрэм, техникийн нөхцөлийн шаардлагыг хангуулах, дамжуулах хоолойн системийн ашиглалтын үйл ажиллагаанд цахилгаан эрчим хүчний бэлэн байдлыг хариуцаж ажиллана.

*Ажлын байранд тавигдах шаардлага:*

- Цахилгааны инженер мэргэжлээр Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Цахилгааны инженерчлэл, зураг төсөл боловсруулах, хянах, барилга угсралтын чанарын хяналтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэргэжлийн болон хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Бичиг хэргийн болон тайлан, мэдээ боловсруулах чадвартай;
- Англи хэлний бичгийн болон ярианы түвшний мэдлэгтэй (TOEFL болон IELTS-н оноотой бол давуу тал болно);
- Тогтвор суурьшилтай ажиллах;
- Хөдөө орон нутагт ажиллах, ажлын ачаалал даах чадвартай;

## 2. Хэмжүүр, автоматикийн инженер

*Гүйцэтгэх үндсэн үүрэг:*

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Алтанширээ сумаас Дорнод аймгийн Матад сум хүртэл үргэлжлэх “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн захиалагчийн багт инженерчлэлийн зураг төсөл хянах, технологийн процессын автоматжуулалт, SCADA телеметр хяналтын систем угсралтын ажилд хяналт тавих, дамжуулах хоолойн системийн ашиглалтын үеийн хэвийн ажиллагааг ханган хариуцаж ажиллана.

*Ажлын байранд тавигдах шаардлага:*

- Автоматжуулалтын инженер мэргэжлээр Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлийн чиглэлээр зураг төсөл боловсруулах, хянах, хэмжих, хэмжүүр хэрэгсэл, тоног төхөөрөмжийн автоматжуулалт суурилуулалт, тохируулгын ажлын туршлагатай;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэргэжлийн болон хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Бичиг хэргийн болон тайлан, мэдээ боловсруулах чадвартай;
- Англи хэлний бичгийн болон ярианы түвшний мэдлэгтэй (TOEFL болон IELTS-н оноотой бол давуу тал болно);
- Тогтвор суурьшилтай ажиллах;

- Хөдөө орон нутагт ажиллах, ажлын ачаалал даах чадвартай;

3. **Барилгын инженер**

*Гүйцэтгэх үндсэн үүрэг:*

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Алтанширээ сумаас Дорнод аймгийн Матад сум хүртэл үргэлжлэх “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн захиалагчийн багт барилга, байгууламжуудын инженерчлэлийн зураг төсөл, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, норм дүрэм, техникийн нөхцөлийн шаардлагыг хангуулж ажиллана.

*Ажлын байранд тавигдах шаардлага:*

- Иргэний ба үйлдвэрийн барилгын инженерийн чиглэлээр Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Захиалагчийн техникийн чанарын хяналт, ил далд ажлын акт, техникийн бичиг баримтыг боловсруулах, бичиг баримтын иж бүрдлийг хангуулах, гүйцэтгэлийн тоо хэмжээг тооцож баталгаажуулах ажлуудыг гүйцэтгэх дадлага туршлагатай байх;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэргэжлийн болон хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Бичиг хэргийн болон тайлан, мэдээ боловсруулах чадвартай;
- Англи хэлний бичгийн болон ярианы түвшний мэдлэгтэй (TOEFL болон IELTS-н оноотой бол давуу тал болно);
- Тогтвор суурьшилтай ажиллах;
- Хөдөө орон нутагт ажиллах, ажлын ачаалал даах чадвартай;

4. **Механик инженер**

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Алтанширээ сумаас Дорнод аймгийн Матад сум хүртэл үргэлжлэх “Газрын тос дамжуулах хоолойн төсөл”-ийн захиалагчийн багт барилга, байгууламжуудын инженерчлэлийн зураг төсөл болон барилга угсралтын ажлын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажилд хяналт тавих, дамжуулах хоолойн системийн ашиглалтын үйл ажиллагаанд техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, засвар үйлчилгээг хариуцаж ажиллана.

*Ажлын байранд тавигдах шаардлага:*

- Механик инженерийн чиглэлээр Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Техник, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын үеийн ажлын акт, техникийн бичиг баримтыг боловсруулах, бичиг баримтын иж бүрдлийг хангуулах, гүйцэтгэлийн тоо хэмжээг тооцож баталгаажуулах ажлыг гүйцэтгэх дадлага туршлагатай;
- Багаар ажиллах чадвартай;
- Мэргэжлийн болон хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Бичиг хэргийн болон тайлан, мэдээ боловсруулах чадвартай;
- Англи хэлний бичгийн болон ярианы түвшний мэдлэгтэй (TOEFL болон IELTS-н оноотой бол давуу тал болно);
- Тогтвор суурьшилтай ажиллах;
- Хөдөө орон нутагт ажиллах, ажлын ачаалал даах чадвартай;